



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/121

Амардалай

Бруцеллэз өвчнөөс урьдчилсан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4,9.5,9.8 заалтууд, Хүнс Хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/151 дугаар тушаал, ХХААХҮ-ийн сайдын 2023 оны 01 дугаар сарын 05-ний өдрийн А/02 дугаар тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 01 ний А/179 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бруцеллэз өвчнөөс урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтыг ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч Д.Наранцэцэг (МЭТ-ийн Улсын байцаагя)

М. Даваацэрэн (Дэлгэрбаяндалай МЭҮН-ийн эмч)

Э.Дэлгэрмаа (Дэлгэрбаяндалай МЭҮН-ийн эмч)

Н.Балданжав (Арвин тэгш баялаг МЭҮН-ийн гэрээт эмч)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

2. 2023 оны 08 дугаар сарын 20-ноос эхлэн 09 сарын 20 хүртэл хугацаанд Мал сүргийг бруцеллэз өвчнөөс урьдчилсан сэргийлэх (тугал ишиг хурга) охин төлийг дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж, САЗ-ыг мөрдөж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын зар тов мэдээг малчдад хүргэн, бэлэн байдлыг хангуулж, мал сүргийг бүрэн хамруулах ажлыг, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай

4. Дархлаажуулалтын явцад хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах, захирамжийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг)-т үүрэг болгосугай

